

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ГЭР БҮЛ, ХҮҮХЭД,
ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР, СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2022 оны 10 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар А/2421 А/76

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9¹ дүгээр зүйлийн 9^{1.4} дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн газар /Г.Мөнхнасан/-т, Соёл, урлагийн газрын Захиргааны хэлтэс /Х.Батсайхан/-т тус тус үүрэг болгосугай.

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА



Г. БАТДОРЖ

СОЁЛ, УРЛАГИЙН
ГАЗРЫН ДАРГА



Н. МӨНХЗУЛ

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын дарга, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 07 өдрийн А/2022, 0/20 дугаар хамтарсан тушаалын хавсралт

“СОЁЛ, СПОРТ, ОЛОН НИЙТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХҮҮХДИЙГ ОРОЛЦУУЛАХ, ЭРХИЙГ ХАМГААЛАХ” ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь хүүхдийг соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд оролцуулах, эрхийг хамгаалах харилцааг зохицуулна.

1.2. Энэ журмыг хэрэгжүүлэхэд Хүүхдийн эрхийн конвенц, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Соёлын тухай хууль, Биеийн тамир, спортын тухай хуулийн холбогдох заалтуудыг удирдлага болгоно.

1.3. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9.1, 9¹.1 дэх хэсэгт заасны дагуу худалдаа үйлчилгээ, соёлын үйл ажиллагаа, урлагийн тоглолт, олон нийтийг хамарсан арга хэмжээ, замын хөдөлгөөн, хүүхэд оролцсон шалгалт, уралдаан спортын тэмцээний үед хүүхдийн эрхийг хамгаалах, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулагч болон оролцогч талууд энэхүү журмыг баримтлана.

1.4. Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагааг зохион байгуулагч болон оролцогч талууд нь дараах зарчмыг баримтална.

- 1.4.1 хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавих;
- 1.4.2 оролцогч хүүхдүүдийг ялгаварлан гадуурхахгүй байх;
- 1.4.3 хүүхдийг язгуур эрх ашгийг хүндэтгэн, хүүхдийн эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг тэгш хангах;
- 1.4.4 хүүхдийн нас, бие сэтгэхүй, төлөвшлийн байдлыг харгалзан, түүний үзэл бодолд хүндэтгэлтэй хандах;
- 1.4.5 хүүхэд оролцох аливаа соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаа нь аливаа нам, эвсэл, хувь хүн болон хуулийн этгээдийн хувийн ашиг сонирхлоос ангид байх;
- 1.4.6 хүүхдийн нас, бие сэтгэхүйн онцлог, хувь хүний нэр төр, хувийн нууцыг хадгалах, нэр төрийг эрхэмлэх;

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.1. Журмын хэрэгжилтийг хангах, хяналт тавих үүргийг Соёл урлагийн газар болон Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хариуцан ажиллах бөгөөд холбогдох асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана.

2.2. Соёл, спорт олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулан зохион байгуулах үйл ажиллагааны удирдамж, зааврыг Соёл, урлагийн болон хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагат хүргүүлж, хамтран ажиллана.